



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2016 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

**Цусны донорыг алдаршуулах, урамшуулах
журам батлах тухай**

Монгол улсын Донорын тухай хуулийн 14, 15 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 124 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:


1. Цусны донорыг алдаршуулах журмыг нэгдүгээр, онооны урамшууллын журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдлөг болгож ажиллахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/-д үүрэг болгосугай.
3. Журмын дагуу зохион байгуулагдсан үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхийг Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны албаны дарга /Б.Цогбадрах/-д үүрэг болгосугай.
4. Уг журмыг хэрэгжүүлэхэд гарах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Гүнжээ/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБЯАР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2016 оны
12 сарын 20-ний өдрийн 4/24 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



ДОНОРЫН ОНООНЫ УРАМШУУЛЛЫН

ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар тухайн жилд бүхэл цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэж байгаа байнгын доноруудын цус өгөлтийн удааг оноогоор тооцон, урамшуулах үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, донор хадгалалтыг сайжруулахад оршино.

Хоёр. Нэр томьёо, тодорхойлолт

- 2.1 Донорын бүртгэл мэдээллийн сан /ДБМС/ гэдэг нь цусны донорын талаарх мэдээлэл агуулсан цахим бүртгэлийн сан;
- 2.2 донорын онооны урамшуулал гэдэг нь тухайн жилд донорын бүхэл цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгөлтийн удаагаар нь тооцон оноонд шилжүүлж, урамшуулах;

Гурав. Донорын онооны урамшуулал

- 3.1 Бүхэл цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ тогтмол бэлэглэсэн доноруудад жилд нэг удаа урамшуулал олгоно;
- 3.2 цус өгөлтийн тоог оноогоор тооцож, онооны дүнг жил бүрийн сүүлийн ажлын өдрөөр тасалбар болгон ДБМС-аас нэгтгэсэн бүртгэлийг гаргана;
- 3.3 тухайн донорт онооны урамшуулал бодогдсон өдрөөс хойш 1 жилийн дотор олгоно;
- 3.4 төвийн захирлаар томилогдсон баг урамшуулалд өгөх гарын бэлгийг сонгон бэлтгэнэ;
- 3.5 донорын үзлэгийн эмч онооны урамшууллын тодорхойлолтын хуудсыг донорт олгож, онооны урамшууллын бүртгэлд донор болон эмч гарын үсэг зурж баталгаажуулалтыг хийнэ;
- 3.6 донорын үзлэгийн эмчийн олгосон тодорхойлолтын дагуу урамшууллын оноонд тохирох бэлгийг донорт аж ахуйн нярав олгоно;
- 3.7 эдийн засагч донорын онооны урамшууллын тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж удирдлагад танилцуулна;

3.8 тухайн донор онооны урамшууллаа 1 жилийн дотор аваагүй тохиолдолд онооны урамшуулал нөхөж олгогдохгүй;

3.9 онооны урамшууллын тодорхойлолтын маягыг хавсаргав;

Дөрөв. Цусны донорын өгөлтийн удаагаар оноо тооцох аргачлал

4.1 Өгөлтийн удааг тооцохдоо дараах зарчмыг баримтлана.Үүнд:


- Бүхэл цусны 1 удаагийн өгөлт-2 оноо /эрэгтэй/;
- Бүхэл цусны 1 удаагийн өгөлт-3 оноо /эмэгтэй/;
- Цусны сийвэнгийн 1 удаагийн өгөлт-1 оноо;
- Улаан болон ялтаст эсийн 1 удаагийн өгөлт- 4 оноо;

4.2 Өгөлтийн удааг оноогоор үржүүлж урамшууллын нийт оноог гаргана.

Тав. Санхүүжилт

5.1 Хуульд заасны дагуу санхүүжилтыг шийдвэрлэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2016 оны
18 сарын 20-ний өдрийн а/б/г тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



ДОНОР АЛДАРШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Авлагагүй сайн дурын цусны донорыг эгнээг өргөжүүлэх, цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ тогтмол хугацаанд бэлэглэж байгаа доноруудын үйлсийг сурталчлах, донор хадгалалтыг сайжруулах.
- 1.2 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийг цусны донорын үйлсэд татан оролцуулах.

Хоёр. Нэр томьёо, тодорхойлолт

- 2.1 Донорын бүртгэл мэдээллийн сан /ДБМС/ гэдэг нь цусны донорын талаарх мэдээлэл агуулсан цахим болон цаасан бүртгэлийн сан;
- 2.2 Донорын эрүүл мэндийн карт /ДЭМК/ гэдэг нь донорын иргэний болон эрүүл мэндийн асуумж, үзлэг, цусаа өгсөн тухай мэдээлэл байна;
- 2.3 Донор алдаршуулах, урамшуулах гэдэг нь тогтмол хугацаанд цусаа бэлэглэсэн донорыг олон нийтэд таниулах, донорын үйлсийг дэмжих, шагнах юм.

Гурав. Донор алдаршуулалт

- 3.1 ДБМА болон донорын үзлэгийн эмч ДБМС-аас 5 болон түүнээс дээш өгөлттэй донорын судалгааг гаргана.
- 3.2 Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч донорын цус өгөлтийн мэдээллийг хянан холбогдох шагналд тодорхойлно.
- 3.3 Төвийн захирлын шийдвэрээр болзол хангасан донорт шагнал олгогдоно.
- 3.4 Донорын цус өгөлтийн удаагаар тооцож болзол хангасан донорыг дараах шагналаар алдаршуулж, урамшуулна. Үүнд :
 - а) "Алтан донор" нь 150 болон түүнээс дээш удаа;
 - б) "Мөнгөн донор" нь 100-аас дээш удаа;
 - в) "Хүрэл донор" нь 70-аас дээш удаа
 - д) "Бахархал" тэмдэг 10, 20, 30, 40, 50, 60 удаа
 - е) Захирлын нэрэмжит "Талархал" нь 5-9 удаа цус, сийвэн эсээ бэлэглэсэн байх;
- 3.5 Маркетингийн нэгж донор алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэдтэй хамтран зохион байгуулах бөгөөд тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж удирдлагад танилцуулна.

3.6 Донор алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааны мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд хүргэхийг хэвлэл мэдээллийн ажилтан хариуцан зохион байгуулна.

Дөрөв. Санхүүжилт

4.1 Хуульд заасны дагуу санхүүжилтыг шийдвэрлэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2016 оны
12 дугаар сарын 20-ний өдрийн 2/504 тоот
тушаалын хавсралт

ДОНОР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАСАГ

Онооны урамшууллын тодорхойлолт

Овог.....Нэр.....

.....онд нийтоноо цуглуулсан тул оноонд
тохирох урамшууллыг сонголтоор олгоно уу.

Донорын үзлэгийн эмч...../гарын үсэг/

.....оны.....сарын.....өдөр

